



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/14

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвд ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх үнийн саналыг хүлээн авч сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:Д.Болормаа (Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал)

Гишүүд:Д.Аззаяа (Гүйцэтгэлийн удирдлага, дотоод хяналтын албаны дарга)


Ц.Лувсандамдин (Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албан дарга)

Э.Түмэнжаргал (Эдийн засагч)

Ч.Ренчиндаваа (Сургалтын менежер)

2.Зөвлөх үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг ажлын хороо (Д.Болормаа)-д даалгасугай.

3.Үнийн санал авахтай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн гишүүн (Э.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН

